



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



“БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ” ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ, ПРОЦЕДУР

**Улаанбаатар хот
2023 он**



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН

Төслийн худалдан авах үйл ажиллагаанд дараах хууль, журам, бодлогын баримт бичгийг мөрддөг. Үүнд:

- МУ, ХБНГУ-ын ЗГ-ын хооронд байгуулсан **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭЛЭЛЦЭЭР**;
- KfW банк болон Сангийн яам хооронд байгуулсан **САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР**;
- KfW банк болон БОАЖЯ-тай байгуулсан **ТУСГАЙ ГЭРЭЭ /SEPARATE AGREEMENT/**;
- ХБНГУ-ын Сэргээн босголт, Зээлийн банк (KfW)-ны “Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөхийн бус үйлчилгээний **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**” /2021 онд шинэчлэгдсэн/;
- МУ-ын **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ**, холбогдох журмууд
- Төслийн үйл ажиллагааны болон худалдан авах үйл ажиллагааны тухайн оны **ТӨЛӨВЛӨГӨӨ**
- БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “**Гэрээ шууд байгуулах**” болон “**Хязгаарлагдмал тендер**”-шалгаруулалтыг зохион байгуулах **Удирдамж** /2021 онд баталсан/
- KfW банкнаас ирүүлсэн “**Гэрээ шууд байгуулах**” болон “**Хязгаарлагдмал тендер**” шалгаруулалтыг зохион байгуулах зөвшөөрөл



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ




ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН

KfW БАНК БОЛОН БОАЖЯ-ТАЙ БАЙГУУЛСАН ТУСГАЙ ГЭРЭЭ /SEPARATE AGREEMENT/

- Тусгай гэрээ нь төслийн хүрээнд санхүүжүүлэх ажил, бараа, үйлчилгээ, түүний санхүүжилт, зарцуулалт, төслийн хэрэгжилтийг зохицуулах эрх зүйн баримт бичиг юм.
- Тусгай гэрээнд төслийн бүрэлдэхүүн хэсгүүд, санхүүжилт, худалдан авах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэгч агентлаг буюу захиалагч, төсөл хэрэгжүүлэх нэгж, төслийн зөвлөх багийн үүрэг хариуцлагыг товч тодорхой тусгаж өгсөн.

“ТҮНШЛЭГЧ УЛСУУДАЙ ХИЙХ САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, АЖИЛ, ҮЙЛДВЭРИЙН БАЙГУУЛАМЖ, БАРААНЫ БОЛОН ЗӨВЛӨХИЙН БУС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ”

- Энэхүү Удирдамжийн зорилго нь худалдан авах ажиллагаа болон гэрээнд KfW-аас тавьж буй шаардлагуудыг тодорхойлж, KfW-ийн хэрэгжүүлэх хяналт, шалгалтын цар хүрээг нарийвчлан тогтооход оршино. Энэхүү Удирдамж нь KfW болон түүний түншүүдийн хооронд байгуулагдсан Санхүүжилтийн Гэрээний нэг хэсэг болно.
- Удирдамж нь нийт 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд:
 1. Үйлчлэх хүрээ болон Худалдан авах ажиллагааны ерөнхий цар хүрээ
 2. Худалдан авах ажиллагааны Ерөнхий нөхцөлүүд
 3. Зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааны журам
 4. Ажил, үйлдвэрийн байгууламж, бараа болон зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам
 5. Төрийн худалдан авах ажиллагааны дүрэм, журамд хамаарахгүй худалдан авах ажиллагаа, санхүүгийн дундын зуучлагч болон бусад онцгой тохиолдлууд






БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН

БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021.02.10-ний өдөр баталсан
“Гэрээ шууд байгуулах” Удирдамж

БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021.07.21-ний өдөр баталсан
“Хязгаарлагдмал тендер”-ийг зохион байгуулах Удирдамж





ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АРГА, ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД

№	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	БОСГО ҮНЭ
1	ОЛОН УЛСЫН НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН ЖУРАМ	<ul style="list-style-type: none">➤ Ажил, үйлдвэр барихад 5,000,000 евро (таван сая евро)-оос дээш➤ Бараа - 1,000,000 еврогоос дээш /2022 онд шинэчлэгдсэн/➤ Зөвлөх болон зөвлөхийн бус үйлчилгээ 200,000 евро (хоёр зуун мянган)-гоос дээш
2	ҮНДЭСНИЙ НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН ЖУРАМ	<ul style="list-style-type: none">➤ Ажил - 5,000,000 евро (таван сая евро) хүртэл➤ Зөвлөх болон Зөвлөхийн бус үйлчилгээний худалдан авалт: 200,000 евро хүртэл.➤ Барааны худалдан авалтад 200,000 – 1,000,000 евро хүртэл /2022 онд шинэчлэгдсэн/
3	ХЯЗГААРЛАГДМАЛ ӨРСӨЛДӨӨН БҮХИЙ ТЕНДЕРИЙН ЖУРАМ	<ul style="list-style-type: none">➤ 20,000 – 200,000 евро хүртэл
4	Үнийн санал ирүүлэх журам	<ul style="list-style-type: none">➤ Бараа, Зөвлөх болон Зөвлөх бус Үйлчилгээний худалдан авалтад 5,000 – 100,000 евро хүртэл.
5	Гэрээ Шууд Байгуулах Журам	<ul style="list-style-type: none">➤ 20,000 (хорин мянга) еврогоос бага үнийн дүн бүхий гэрээнд.



Олон улсын нээлттэй тендер – International Competitive Bidding (ICB)

№	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	БОСГО ҮНЭ	ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА
1	ОЛОН УЛСЫН НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН ЖУРАМ	<ul style="list-style-type: none"> ➤ Ажил, үйлдвэр барихад 5,000,000 евро (таван сая евро)-оос дээш ➤ Бараа - 1,000,000 еврогоос дээш /2022 онд шинэчлэгдсэн/ ➤ Зөвлөх болон зөвлөхийн бус үйлчилгээ 200,000 евро (хоёр зуун мянган)-гоос дээш 	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хамтын ажиллагаанд мөрддөг стандарт журам.

Онцлог, үе шат

Захиалагчийн ашиглах жишиг бичиг баримт	Тендерийн жишиг бичиг баримтад хийсэн өөрчлөлт	Нийтэд зарлан мэдээлэх хэрэгсэл	Тендер хүлээн авах эцсийн хугацаа	Тендерийн хүчинтэй хугацаа	KfW банкны хяналт шалгалтын оролцоо	KfW банкнаас шалгах нэгж	Хяналтын хэлбэр	Зөвшөөрлийн хэлбэр	Тендерийн хэл
- KfW-н жишиг тендерийн бичиг баримт	- ОУНТ-ийн жишиг бичиг баримт	ГТАИ, БОАЖЯ, Төслийн цахим хуудас, Өдөр тутмын хэвлэл * 2022 оноос эхлэн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд зарлан мэдээлэхээр болсон.	45 хоног	120 хоног	- Худалдан авах ажиллагааны үе шатанд бүрт*	- Худалдан авах ажиллагааны газар	- Урьдчилсан хяналт /Prior-review/	- Үл татгалзах тухай мэдэгдэл (NOL)-ийг албан тоотгоор KfW-банкнаас ирүүлдэг	- Англи хэл

* Тендерийн үе шат бүрд зөвшөөрөл авах, хяналт хийхэд дунджаар 10-14 хоног зарцуулдаг. (Иймд ОУНТ нь 120 хоног багадаа шаарддаг.)



Үндэсний нээлттэй тендер - National Competitive Bidding (NCB)

№	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	БОСГО ҮНЭ	ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА
2	ҮНДЭСНИЙ НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН ЖУРАМ	<ul style="list-style-type: none"> ➤ Ажил - 5,000,000 евро (таван сая евро) хүртэл ➤ Зөвлөх болон Зөвлөхийн бус үйлчилгээний худалдан авалт: 200,000 евро хүртэл. ➤ Барааны худалдан авалтад 200,000 – 1,000,000 евро хүртэл. 	<ul style="list-style-type: none"> • Үндэсний түвшинд тоо хэмжээ болон чанарын хувьд хангалттай өрсөлдөөн бүхий байх; • Гэрээт ажлын цар хүрээ болон гэрээг хэрэгжүүлэх нөхцөлүүд нь олон улсын түвшинд биш байх (тухайлбал төслийн хэмжээ, логистикийн шалтгаанууд болон үнэ гэх мэт).

Онцлог, үе шат

Захиалагчийн ашиглах жишиг бичиг баримт	Тендерийн жишиг бичиг баримтад хийсэн өөрчлөлт	Нийтэд зарлан мэдээлэх хэрэгсэл	Тендер хүлээн авах эцсийн хугацаа	Тендерийн хүчинтэй хугацаа	KfW банкны хяналт шалгалтын оролцоо	KfW банкнаас шалгах нэгж	Хяналтын хэлбэр	Зөвшөөрлийн хэлбэр	Тендерийн хэл
- KfW-н жишиг тендерийн баримт бичиг	Ерөнхий шаардлага: - Үүрэг биелүүлэх тухай амлалт /Маягт/ - Хариуцлага тооцох үйлдэл /Мэдэгдэл/ - Нийгмийн болон байгаль орны хариуцлага /Мэдэгдэл/	БОАЖЯ, Төслийн цахим хуудас, Өдөр тутмын хэвлэл * 2022 оноос эхлэн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд зарлан мэдээлэхээр болсон.	30 хоног	30 хоног /доошгүй/	- Тендерийн процедур дууссаны дараа түүвэр хэлбэрээр тухайн тендерт холбогдох бүхий л бичиг баримтад хяналт шалгалт хийх	- Дотоод аудитын газар	- Дараах хяналт /Post-review/	- Захиалагч тендер шалгаруулалтын бүрээр баталдаг	- Монгол хэл - Түүврээр сонгогдсон тендерийн бүхий л бичиг баримтыг орчуулж хүргүүлэх үүрэг захиалагч тал хүлээсэн



Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендер - Limited Competitive Bidding (LCB)

№	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	БОСГО ҮНЭ
3	ХЯЗГААРЛАГДМАЛ ӨРСӨЛДӨӨН БҮХИЙ ТЕНДЕРИЙН ЖУРАМ	20,000 – 200,000 евро хүртэл

Ерөнхий нөхцөл, шаардлага, онцлог

2.1.3 Хязгаарлагдмал Өрсөлдөөнт Тендерийн Журам

ХӨТ-ийн Журмыг баримтлах тохиолдолд Тендерийн ажиллагааг Тендер ирүүлэх урилга авсан хязгаарлагдмал тооны урьдчилан сонгогдсон, шалгуур хангасан Этгээдүүдийн хүрээгээр хязгаарлана.

Ерөнхийдөө, **гурваас /3/ доошгүй тооны Этгээдэд** Тендерийн Санал ирүүлэх хүсэлт тавина. Ингэхийн тулд ТХА нь санал болгож буй Тендерийн Санал ирүүлэхээр сонгогдсон Этгээдүүдийн жагсаалтыг зардлын тооцооны хамт KfW-д танилцуулах бөгөөд төлөвлөж буй үйл ажиллагаатай холбогдуулан тухайн Этгээдүүдийн чадавхыг, тухайлбал тухайн Гэрээний зүйлийн хувьд холбогдох ерөнхий туршлага, шаардлагатай хүний нөөц, санхүүгийн эх үүсвэр, мэргэшсэн байдлын талаар нотлох үүрэгтэй. Хангалттай мэдээлэл байхгүй тохиолдолд Тендерт Оролцогчдыг Тендерийн хамт дээр дурдсан чадавхыг хангаж буйгаа нотолсон дэлгэрэнгүй мэдээлэл хамт ирүүлэхийг шаардаж болно.

ХӨТ-ийн журмыг дараах тохиолдолд сонгон хэрэглэнэ:

- (1) тухайн гэрээний үнийн дүнгээс шалтгаалж ҮНТ-ийн журмыг хэрэглэх боломжгүй бөгөөд бол Төрийн Худалдан Авах Ажиллагааны Дүрэм, Журмаар зөвшөөрсөн бол ОУНТ-ийн босгоос бага үнэлгээтэй Гэрээнүүдэд,
- (2) Зөвхөн хязгаарлагдмал цөөн тооны Этгээдүүд тухайн Гэрээний шаардлагыг хангах чадвартай бөгөөд үүнийг зах зээлийн мэдээллээр нотлон харуулах боломжтой тохиолдолд ОУНТ-ийн босгоос давсан үнэлгээтэй Гэрээний хувьд, эсвэл
- (3) Гэрээний үнийн дүнгээс үл хамааран, зах зээлийн өөр бусад нөхцөл байдлаас шалтгаалж шударга өрсөлдөөн явагдахгүй гэж үзсэн тохиолдолд (тухайлбал ашгийн төлөө байгууллагын эсрэг ашгийн бус байгууллага оролцох гэх мэт)



Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендер (ХӨТ) - Limited Competitive Bidding (LCB)

№	Хийгдэх алхам, үе шатууд	Хугацаа /ажлын хоног/	Гарах баримт бичиг
1	Үнэлгээний хороо байгуулах	-	ТНБД-ын тушаал
2	Үнэлгээний хороо (№01 хурал) ажлын даалгавар, тендерийн баримт бичгийн төслийг боловсруулах, захиалагчаар батлуулах	1	Санхүүжүүлэгчээр болон Захиалагчаар батлагдсан төсөв бүхий ажлын даалгавар, тендерийн баримт бичиг
3	Тендерийн урилгыг (тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх хүсэлт ирүүлэх) ТХАА-ны цахим хуудас www.tender.gov.mn, БОАЖЯ, төслийн цахим хуудас болон үндэсний өдөр тутмын 2 сонинд тус тус нийтлэх	5	Тендерийн урилга (тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх хүсэлт ирүүлэх)
4	Үнэлгээний хороо (№02 хурал) тендерт оролцох сонирхлоо илэрхийлсэн байгууллагуудаас дор хаяж 3 байгууллагыг хураангуй жагсаалт оруулж, тендерт оролцох урилга, тендерийн баримт бичгийн хамт хүргүүлэх	4	Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, хураангуй жагсаалт, тендерийн урилга, тендерийн баримт бичиг
5	Тендерт оролцох урилга хүлээн авсан байгууллагууд тендерээ бэлтгэх	15	Тендерийн санал ирүүлнэ. Бэлтгэх хугацаа хуанлийн 20 хоног байна. (KfW банкны худалдан авах ажиллагааны журмын 2.4.10 заалт.)
6	Тендерт оролцогч тендерээ ирүүлэх	1	Техникийн болон санхүүгийн санал
7	Үнэлгээний хороо (№03 хурал) техникийн саналын нээлт, үнэлгээ хийх	2	Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, техникийн саналын үнэлгээний тайлан, тендерийн мэдэгдэл
8	Үнэлгээний хороо (№04 хурал) санхүүгийн саналын нээлт, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах	2	Тендерийн нээлтийн тэмдэглэл, хурлын тэмдэглэл, зөвлөмж, үнэлгээний товч тайлан
9	Үнэлгээний хороо ТНБД-д зөвлөмж хүргүүлэх	2	ТНБД-ын зөвлөмжтэй танилцсан цохолт
10	Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлэх	1	Тендерийн мэдэгдэл
11	Шалгарсан гэрээлэгчтэй гэрээний өмнөх уулзалтыг хийх	1	Хурлын тэмдэглэл
12	Гэрээ байгуулах	1	Гэрээ
	Нийт хугацаа	35	



Гэрээ шууд байгуулах - Direct Award (DA)

Ерөнхий нөхцөл, шаардлага, онцлог

2.1.5 Гэрээ Шууд Байгуулах Журам

Гэрээ шууд байгуулах журмыг хэрэглэх тохиолдолд, ТХА-ын боловсруулсан ажлын тодорхойлолт, шаардлага, эсхүл **ажлын даалгавар зэрэгт үндэслэн шалгуур хангаж урьдчилан сонгогдсон цорын ганц Этгээдийг Тендер ирүүлэхийг урина**. ТХА нь тухайн Санал болон Гэрээний шаардлагад нийцсэн болон өрсөлдөхүйц байгааг баталгаажуулж, сонгогдсон Тендерг оролцогчийг шалгуур хангасан болохыг батлах үүрэгтэй. Энэхүү баталгаажуулах явц, түүнээс гарсан үр дүнг бичгэн хэлбэрээр баримтжуулна. Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах тохиолдлуудад сонгож хэрэглэнэ:

(1) дараах байдлаар өмнө нь байгуулагдсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд:

- a) нэмэлт өөрчлөлт нь Гэрээний анхны үнийн дүнгийн 25 хувиас хэтрээгүй (зарчмын хувьд Гэрээний анхны үнийн 25%-аас бага байх ёстой), эсхүл тухайн нэмэлт өөрчлөлт нь дахин шинээр Тендерийн ажиллагаа явуулах хангалттай үндэслэл болж чадахгүй гэж үзсэн бол, мөн
- b) тухайн нэмэлт өөрчлөлтийн шинж чанар, цар хүрээ нь анхны Гэрээний зүйл, болон агуулгыг өөрчлөөгүй бол;

(2) аливаа төслийн дараа дараагийн үе шатуудад дараах нөхцөл, шаардлагууд бүгд хангагдсан тохиолдолд

- (a) өмнөх Тендерийн Баримт Бичгүүдэд заасны дагуу дараагийн шатанд илүү анхаарал хандуулахаар болсон бол,
- (b) анхны Гэрээг байгуулах эрхийг нээлттэй уралдаант шалгаруулалтын үндсэн дээр олгосон бол,
- (c) Гүйцэтгэгчийн өмнөх шатанд хийж гүйцэтгэсэн гүйцэтгэл нь шаардлагад нийцсэн бол, мөн
- (d) ажлын даалгавар эсхүл техникийн үзүүлэлтүүдийн дийлэнх хэсэг нь адилхан бол;

(3) 2.5.15-р зүйлд заасны дагуу Тендерийн Ажиллагааг цуцалснаас хойш, дараах тохиолдолд

- a) Гэрээгээр анхлан тохирсон нөхцөлүүдэд томоохон, зарчмын шинж чанартай өөрчлөлт ороогүй, мөн
- b) дахин шинээр тендерийн ажиллагаа явуулснаар зохих үр дүн гарахааргүй бол;

(4) нэн яаралтай дараах шалтгаанаар, үүнд

- a) ТХА-с хамаарахгүй шалтгаанаар урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлын улмаас (тухайлбал, байгалийн гамшиг, хямрал, зөрчил гэх мэт), болон
- b) 2.4.10-р зүйлд заасан болон бусад журмаар тогтоосон цаг хугацааг баримтлах боломжгүй бол;

(5) онцгой тохиолдлуудын улмаас, үүнд мэргэшил болон туршлага хосолсон байх шаардлага, техникийн шалтгаан/үзүүлэлт, эсхүл онцгой эрхийг хамгаалах Түншлэгч Улсуудтай хийх Санхүүгийн Хамтын Ажиллагаа дахь Зөвлөх Үйлчилгээ, Ажил, Үйлдвэрийн байгууламж, Бараа болон Зөвлөх бус Үйлчилгээ Худалдан Авах Ажиллагааны Удирдамж шаардлагаар Гэрээг зөвхөн тодорхой нэг Этгээд хэрэгжүүлэх боломжтой тохиолдолд;

(6) 20,000 (хорин мянга) еврогоос бага үнийн дүн бүхий Гэрээнд.



Гэрээ шууд байгуулах (ГШБ) - Direct Award (DA)

№	Гэрээ шууд байгуулах үед хийгдэх алхмууд	Хугацаа /ажлын хоног/	Гарах баримт бичиг
1	Үнэлгээний хороо байгуулах	1	ТНБД-ын тушаал
2	Ажлын даалгавар боловсруулах	5	Ажлын даалгавар
3	Үнэлгээний хороо №01 хурал хийж, 1 сонгогдсон зөвлөхөд урилга, ажлын даалгавар хүргүүлэх	1	Хурлын тэмдэглэл, зөвлөхийн ажлын даалгавар
4	Зөвлөх саналаа бэлтгэх /техникийн болон санхүүгийн/	5	Техникийн болон санхүүгийн санал
5	Үнэлгээний хороо №02 хурал хийж, Зөвлөхөөс ирүүлсэн техникийн болон үнийн саналыг хүлээн авч үнэлгээ хийх, дүгнэлт гаргах	1	Хурлын тэмдэглэл, зөвлөмж
6	Үнэлгээний хороо ТНБД-д зөвлөмж хүргүүлэх	1	Зөвлөмж дээр ТНБД-ын цохолт
7	Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлэх	1	Мэдэгдэл
8	Зөвлөхтэй гэрээний хэлэлцээр хийх	1	Хурлын тэмдэглэл
9	Гэрээ байгуулах	1	Гэрээ
	Нийт хугацаа	17 хоног	



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Онцлог тал

- Санхүүжүүлэгч байгууллагын тендерийн жишиг баримт бичгийг (бараа, ажил, зөвлөх үйлчилгээ) ашигладаг.
- Санхүүжүүлэгч байгууллагаас явцын үнэлгээг жил бүр хийгддэг (тендерүүдээс санамсаргүй түүврийн аргаар сонгох)
- Төслийн үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийгддэг (Үндэсний Аудитын Газар)
- Тендерийн үр дүнг төрийн худалдан авах үйл ажиллагааны цахим систем болон төслийн цахим хуудаст мэдээлдэг.
- Төслийн зөвлөх баг нь худалдан авах ажиллагаа тус бүрийн үзэл баримтлал /concept/-ийг KfW-аас “Үл татгалзах тухай мэдэгдэл” (NOL) зөвшөөрөл авдаг.
- KfW-аас 2021 онд Барааны жишиг баримт бичигт, 2022 онд Зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичигт зөвшөөрөл авсан, 2023 онд Барилгын ажлын тендерийн жишиг баримт бичигт зөвшөөрөл авна.
- ОУНТШ-ын /Ажил – 5 сая, Бараа – 1 сая, Зөвлөх үйлчилгээ – 200 мянга/ үед худалдан авах ажиллагааны бүх үе шатанд санхүүжүүлэгч тал хяналт хийснээр KfW банк “Үл татгалзах тухай мэдэгдэл” (NOL) зөвшөөрөл авдаг.

Анхаарал тавьсанд баярлалаа